



ХОВД АЙМАГ  
МӨНХХАЙРХАН СУМЫН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2017 оны 07 сарын 26 өдөр

Дугаар 33

Сэнхэр

Г Төлөөлөгчдийн өдөр зохион байгуулах тухай Г

Монгол улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.2 дахь заалтыг үндэслэн сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын "Төлөөлөгчдийн өдөр"-ийг 2017 оны 8 дугаар сарын 02-ны өдрийн "Лхагва" гарагт сумын төвд зохион байгуулж дараах асуудлыг хэлэлцүүлсүгэй.

1/ Сумын 90 жилийн ойн хандивын бүрдүүлэлт, зарцуулалтын тайлан

2/ Сумын 90 жилийн ойн хүрээнд хийгдсэн бүтээн байгуулалтын ажилтай танилцах

2. Төлөөлөгчдийн өдрийн бэлтгэл ажлыг сайтар хангаж, үр дүнтэй зохион байгуулахыг Нарийн бичгийн дарга (О.Бишгарам)-д даалгасугай.

ХУРЛЫН ДАРГА



Я.ОЧИР



ХОВД АЙМАГ  
МӨНХХАЙРХАН СУМЫН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2017 оны 08 сарын 01 өдөр

Дугаар 34

Сэнхэр

Г “Орчны бүсийн зөвлөл” шинэчлэн Г  
байгуулах тухай

Монгол улсын Тусгай хамгаалалттай газар нутгийн орчны бүсийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх заалтыг үндэслэн сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Мөнххайрхан сумын тусгай хамгаалалттай газар нутгийн орчны бүсийн зөвлөлийг шинэчлэн байгуулж, бүрэлдэхүүнийг хавсралтаар баталсугай.

2. Орчны бүсийн хөгжлийг зохицуулах, байгалийн баялгийг зүй зохистой ашиглах, хамгаалах, нөхөн сэргээхэд иргэдийн оролцоог нэмэгдүүлэхэд чиглэсэн сургалт сурталчилгааг зохион байгуулж, хууль тогтоомж болон орчны бүсийн менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Зөвлөлийн бүрэлдэхүүнд даалгасугай.

3. Зөвлөлийн ажлын тайланг жил бүрийн 10 дугаар сард багтаан сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдэд танилцуулж ажиллахыг зөвлөлд үүрэг болгосугай.

4. Тогтоол гарсантай холбогдуулан сумын ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2013 оны 5 дугаар сарын 02-ны өдрийн 38 дугаар тогтоол, 2014 оны 9 дүгээр сарын 26-ны өдрийн 37 дугаар тогтоолыг тус тус хүчингүйд тооцсугай.

ХУРЛЫН ДАРГА



Я.ОЧИР

Мөнххайрхан сумын иргэдийн Төлөөлөгчдийн  
Хурлын Тэргүүлэгчдийн 2017 оны 8 дугаар сарын 01-ны  
өдрийн 34 дүгээр тогтоолын хавсралт



МӨНХХАЙРХАН СУМЫН ТУСГАЙ ХАМГААЛАЛТАЙ  
ГАЗАР НУТГИЙН ОРЧНЫ БҮСИЙН ЗӨВЛӨЛ

- |                  |   |
|------------------|---|
| 1.М.Одхүү        | -БЦГ-ын хамгаалалтын захиргааны даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч |
| 2. Г.Баянмөнх    | -БЦГ-ын хамгаалалтын захиргааны мэргэжилтэн                         |
| 3. Я.Очир        | -Сумын ИТХ-ын тэргүүлэгч  |
| 4. Б.Цэндпүрэв   | -Сумын ИТХ-ын тэргүүлэгч  |
| 5.Т.Буянхишиг    | -Борт багийн иргэн  |
| 6.А.Батзориг     | -Алаг багийн иргэн  |
| 7.Д.Маамбаа      | -Сэнхэр багийн иргэн  |
| 8.Д.Даваасүрэн   | -Алаг багийн ИНХ-ын дарга   |
| 9.Б.Батзаяа      | -Хаг багийн ИНХ-ын дарга  |
| 10.Б.Анхтуяа     | -Хаг багийн малчин, нөхөрлөлийн гишүүн                              |
| 11.Б.Булганчимэг | -Сумын БОХУ-ын байцаагч   |

-о о о-



ХОВД АЙМАГ  
МӨНХХАЙРХАН СУМЫН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2017 оны 08 сарын 01 өдөр

Дугаар 35

Сэнхэр

┌ Эд хөрөнгө олж авахыг зөвшөөрөх тухай ┐

Монгол улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1-ын "б" заалт, Төрийн болон Орон нутгийн өмчийн тухай хуулийн 6, 75 дугаар зүйл, 77 дугаар зүйлийн 77.2.3, 77.3 дахь заалт, аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2013 оны 30 дугаар тогтоолоор батлагдсан "Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн үндсэн хөрөнгийг олж авах, бүртгэх, шилжүүлэх, худалдах, акталж устгах, данснаас хасах, тайлагнах журам"-ын 2 дугаар зүйлийн 2.7 дахь заалтуудыг тус тус үндэслэн сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1.Төрийн болон Орон нутгийн өмчит байгууллагуудын үндсэн хөрөнгөнд 2017 онд нийт 23 нэр төрлийн 74 ширхэг эд хөрөнгийг 14534.0 мянган төгрөг (арван дөрвөн сая таван зуун гучин дөрвөн мянга)-өөр байгууллагын батлагдсан төсөв, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний зардлын эх үүсвэрээс авахыг зөвшөөрсүгэй.

2. Шинээр олж авах эд хөрөнгийн жагсаалтыг хавсралтаар баталсугай.

3.Эд хөрөнгө олж авах арга хэмжээг хуулийн хүрээнд зохион байгуулж, худалдан авсан эд хөрөнгө, тоног төхөөрөмж, бусад үндсэн хөрөнгийг журмын дагуу данс бүртгэлд тусгаж, тогтоолын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг сумын Засаг дарга (Б.Батболд), албан байгууллагуудын дарга, нягтлан бодогч, нярав нарт үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА



Я.ОЧИР

Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн  
2017 оны 8 дугаар сарын 31 ны өдрийн 35 дугаар  
тогтоолыг хавсралт



МӨНХХАЙРХАН СУМЫН ТӨРИЙН БОЛОН ОРОН НУТГИЙН ӨМЧИТ БАЙГУУЛЛАГУУДЫН  
2017 ОНД ШИНЭЭР ОЛЖ АВАХ ЭД ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

д/д	Эд хөрөнгийн нэр	марк	Хүчин чадал		тоо хэмжээ	нэг бүрийн үнэ	нийт үнэ	эх үүсвэр	
			хэмжих нэгж	биет хэмжээ					
<b>Соёлын төв</b>									
1	Ятга хөгжим	модон	ш	16 утастай	2	340000	680000	Уран бүтээлийн зардал, төсөл, хөтөлбөр, хандив, тусламжийн эх үүсвэрээр	
2	Морин хуур	модон	ш	Хос чавхдастай	5	400000	2000000		
3	Ятга хөгжмийн утас	сатурка	ком	16 ширхэг ком утас	1	90000	90000		
4	Зөөврийн компьютер	Dell	ш	4GB	1	1200000	1200000		
5	Пульт микшер		ш	700V	1	750000	750000		
6	Зөөврийн чанга яригч		ш	Хос /500 вт/	1	820000	820000		
7	Утасгүй микрофон		ком	Хос микрофон, станцын хамт	1	280000	280000		
8	Проектор		ш		1	560000	560000		
9	Гэрлэн хаяг		ком	9 үсэг	1	450000	450000		
10	Морин хуурын утас	хялгас	ш	хос	10	15000	150000		
11	Морин хуурын нум /сымчак/		ш	Утас нумын хамт	10	15000	150000		
12	Гэр интернет		ш	4 гаралттай	1	200000	200000		
13	Тайзны гэрэлтүүлэг			100 W	4	45000	180000		
14	Бүжгийн гутал	савхи	хос	Гоёлын тоногтой	10	60000	600000		
<b>ДҮН</b>					<b>49</b>		<b>8110000</b>		
<b>Хүүхдийн цэцэрлэг</b>									
1	Угаалгын машин	Hair	ш	2000 w	3	240000	720000	эд хогшил худалдан авах зардал, төсөл, хөтөлбөр, хандив тусламжаар	
2	Тоос сорогч	Hair	ш	2000 w	1	230000	230000		
3	Ус цэвэршүүлэгч	Majic	ш	өндөр 1.2 м, өргөн 0.5м	4	560000	2240000		
4	Ном гарын авлага	эмхтгэл	ш		4	16000	64000		
5	Өсгөгч	Divine	ш	700 w	1	700000	70000		
6	Яригч микрофон	Divine	ш	700 w	1	750000	750000		
7	Яригч /бага оврын/	Divine	ш		3	250000	750000		
8	Зурагт	LCD	ш	32 инч	3	450000	1350000		
9	Хашааны тор	төмөр	боодол		5	50000	250000		
<b>ДҮН</b>					<b>25</b>		<b>6424000</b>		
<b>НИЙТ ДҮН</b>								<b>14534000</b>	



ХОВД АЙМАГ  
МӨНХХАЙРХАН СУМЫН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2017 оны 08 сарын 01 өдөр

Дугаар 36

Сэнхэр

ГСумын 2018 оны төсвийн төсөл дэмжих тухай

Монгол улсын Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4.1 дэх заалтыг үндэслэн "Сумын 2018 оны төсвийн төслийг дэмжүүлэх тухай" сумын ерөнхий нягтлан бодогч Э.Эрэндаваагийн илтгэлийг хэлэлцээд сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1.Сумын 2018 оны Орон нутгийн орлогын төслийг 20965.0 мянган төгрөгөөр, Орон нутгийн төсөвт байгууллагуудын зарлагыг 392429.5 мянган төгрөгөөр, Орон нутгийн хөгжлийн сангийн зарлагыг 105000.0 мянган төгрөгөөр тус тус тооцсоныг дэмжсүгэй.

2.Засгийн газрын зарим чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагуудын зарлагыг 12 жилийн сургууль 675073.2 мянган төгрөгөөр, Хүүхдийн цэцэрлэг 229983.0 мянган төгрөгөөр, Соёлын төв 64421.8 мянган төгрөгөөр, Эрүүл мэндийн төв 273408.2 мянган төгрөгөөр тус тус тооцсоныг дэмжсүгэй.

3.Төсвийн төслийг сумын дүнгээр нэгтгэн заавар журмын дагуу боловсруулан аймгийн санхүү, төрийн сангийн хэлтэст хүргүүлэхийг ерөнхий нягтлан бодогч /Э.Эрэндаваа/-д даалгасугай.

ХУРЛЫН ДАРГА



Я.ОЧИР



ХОВД АЙМАГ  
МӨНХХАЙРХАН СУМЫН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2017 оны 08 сарын 16 өдөр

Дугаар 34

Сэнхэр

Нөхөн сонгууль товлон зарлах тухай

Монгол улсын Сонгуулийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2, 20 дугаар зүйлийн 20.1 дэх заалтыг тус тус үндэслэн сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1.Орон нутгийн Хурлын төлөөлөгчийн нөхөн сонгуулийг Борт багийн 1257 дугаар хэсэгт 2017 оны 10 дугаар сарын 08-ны өдрийн "Ням" гарагт явуулахаар товлон зарласугай.

2.Нөхөн сонгууль явуулах хугацааг иргэд сонгогчдод зарлан мэдээлж, сонгуулийн үйл ажиллагаанд бүх талаар тусалж, холбогдох зардлыг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхийг сумын Засаг дарга /Б.Батболд/-д даалгасугай.

3.Борт багийн 2 дугаар тойрогт нэг мандатын төлөө Орон нутгийн Хурлын 2016 оны сонгуульд оролцсон намууд намаас нэр дэвшүүлэх, иргэд бие даан нэрээ дэвшүүлэх эрхтэйг зөвлөсүгэй.

ХУРЛЫН ДАРГА



Я.ОЧИР



ХОВД АЙМАГ  
МӨНХХАЙРХАН СУМЫН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧИЙН ХУРЛЫН  
ТЭРГҮҮЛЭГЧИЙН ТОГТООЛ

2017 оны 08 сарын 16 өдөр

Дугаар 38

Сэнхэр

Сонгуулийн хороо байгуулах тухай

Монгол улсын Сонгуулийн тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь заалтыг үндэслэн сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1.Орон нутгийн Хурлын төлөөлөгчийн нөхөн сонгуулийг удирдан зохион байгуулах сумын Сонгуулийн хороог дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Дарга:	О.Бишгарам	-Сумын ИТХ-ын нарийн бичгийн дарга
Нарийн бичгийн дарга:	Б.Булганчимэг	-Сумын БОХ-ын улсын байцаагч
Гишүүд:	Р.Цоож	-Нийгмийн даатгалын байцаагч
	О.Алтансүвд	-Халамж үйлчилгээний мэргэжилтэн
	Ц.Тунгалаг	-ЗДТГ-ын эрхзүйн ажилтан

2.Нөхөн сонгууль явуулах хэсгийн санал авах байрны бүрэлдэхүүнийг томилж, сонгуулийг хуулийн хүрээнд товлосон хугацаанд хариуцлагатай зохион байгуулж, дүнг сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд танилцуулахыг Сонгуулийн хорооны дарга /О.Бишгарам/, гишүүдэд үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА



Я.ОЧИР





ХОВД АЙМАГ  
МӨНХХАЙРХАН СУМЫН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2017 оны 09 сарын 01 өдөр

Дугаар 39

Сэнхэр

Г Нөхөн сонгуулийн тов өөрчлөн тогтоох тухай Г

Монгол улсын Сонгуулийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2, 20 дугаар зүйлийн 20.1 дэх заалт, Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.4 дэх заалтыг тус тус үндэслэн сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1.Орон нутгийн Хурлын төлөөлөгчийн нөхөн сонгуулийн товыг 2017 оны 10 дугаар сарын 01-ны өдрийн “Ням” гарагт явуулахаар өөрчлөн тогтоосугай.

2.Нөхөн сонгуулийн тов өөрчлөгдсөн хугацааг иргэд сонгогчдод зарлан мэдээлэхийг сумын Засаг дарга /Б.Батболд/, багийн Засаг дарга /Б.Бөхболд/ нарт даалгасугай.

3.Тогтоол гарсантай холбогдуулан сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2017 оны 8 дугаар сарын 16-ны өдрийн 37 дугаар тогтоолыг хүчингүйд тооцсугай.

ХУРЛЫН ДАРГА



Я.ОЧИР